# ХАДГАЛАМЖ, ЗЭЭЛИЙН ХОРШООДЫН 2013 ОНЫ ЖИЛИЙН ЭЦСИЙН САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН НЭГТГЭЛИЙН ТАНИЛЦУУЛГА

2014.02.27 Улаанбаатар хот

## НЭГ. ӨНӨӨГИЙН БАЙДЛЫН ТАЛААР

Тайлант жилд Хорооны хуралдаанаар 2 ХЗХ-нд хадгаламж, зээлийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл шинээр олгож, 9 ХЗХ-ны тусгай зөвшөөрлийг хүчингүй болгож, 73 ХЗХ-ны тусгай зөвшөөрлийн хугацааг сунгаж, 5 ХЗХ-ны тусгай зөвшөөрлийг түдгэлзүүлж 2013 оны жилийн эцсийн байдлаар нийт 141 хадгаламж, зээлийн хоршоо /цаашид “ХЗХ” гэх/ Хорооноос олгосон тусгай зөвшөөрөлтэйгөөр хадгаламж, зээлийн үйл ажиллагаа эрхэлж байна.

ХЗХ-дын тооны өөрчлөлтийг сүүлийн 8 жилийн байдлаар харуулбал:



| | 2006 | 2007 | 2008 | 2009 | 2010 | 2011 | 2012 | 2013 |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| Нийт ХЗХ-ны тоо | 51 | 179 | 209 | 212 | 179 | 162 | 148 | 141 |
| УБ хотод үйл ажиллагаа эрхэлж буй ХЗХ-дын тоо | 46 | 99 | 101 | 95 | 74 | 71 | 64 | 57 |
| Орон нутагт үйл ажиллагаа эрхэлж буй ХЗХ-дын тоо | 5 | 80 | 108 | 117 | 105 | 91 | 84 | 84 |
| Нийт гишүүдийн тоо | 5,150 | 21,667 | 24,655 | 28,069 | 25,990 | 26,882 | 26,004 | 27,245 |

Хорооны хуралдаанаар тусгай зөвшөөрөлтэй ХЗХ -дын асуудлыг шийдвэрлэсэн байдлыг хүснэгтээр харуулбал:

| Онууд | шинээр олгосон | хүчингүй болгосон | түдгэлзүүлсэн | сэргээсэн | ТЗ-ийн хугацаа сунгасан | ХЗХ-дын тоо |
|---|---|---|---|---|---|---|
| 2006 | 51 | 0 | 0 | - | - | 51 |
| 2007 | 128 | 0 | 0 | - | - | 179 |
| 2008 | 45 | 15 | 5 | - | - | 209 |
| 2009 | 15 | 12 | 8 | 1 | 25 | 212 |
| 2010 | 2 | 35 | 15 | 4 | 80 | 179 |
| 2011 | 4 | 21 | 9 | - | 47 | 162 |
| 2012 | 3 | 17 | 7 | 4 | 26 | 148 |
| 2013 | 2 | 9 | 5 | - | 76 | 141 |

Нийт ХЗХ-дын 97.2 хувь буюу 137 ХЗХ-ноос 2013 оны дөрөвдүгээр улирлын санхүүгийн болон зохистой харьцааны шалгуурүзүүлэлтийн тайлан ирүүлсэн, харин 2.8 хувь буюу 4 ХЗХ нь тайлан мэдээг ямар нэг хүндэтгэн үзэх шалтгаангүйгээр Хороонд ирүүлээгүй байна.

2013 оны дөрөвдүгээр улирлын байдлаар санхүүгийн тайлангийн нэгтгэлд тайлан мэдээгээ ирүүлээгүй 4 ХЗХ-ны нэгтгэлд хамруулсан үеийн буюу хамгийн сүүлд Хороонд ирүүлсэн санхүүгийн тайланг хугацааны хувьд авч үзвэл дараах байдалтай байна. Үүнд:

| д/д | Тайлангийн хугацаа | ХЗХ-ны тоо | ХЗХ-дын нэрс |
|---|---|---|---|
| **1** | 2013- I улирлаар | 1 | Өвөрхангай аймгийн Найдвартай хөгжил |
| **2** | 2013- II улирлаар | 2 | Завхан аймгийн Нугын дэвшил, Улаанбаатар хотын Гэрэг инвест |
| **3** | 2013- III улирлаар | 1 | Улаанбаатар хотын Мон инвест |
| | **Нийт** | 4 | |

## ХОЁР. НЭГТГЭЛИЙН СТАТИСТИК ҮЗҮҮЛЭЛТҮҮД

### *2.1 Ерөнхий статистик үзүүлэлтүүд*

/тоогоор/

| СТАТИСТИК МЭДЭЭЛЭЛ* | НИЙТ |
|---|---|
| Нийт гишүүдийн тоо | 27,245 |
| Үүнээс: эмэгтэй | 14,152 |
| **Гишүүдийн насжилт** | |
| 18-35 насны | 6,504 |
| 36-45 насны | 8,378 |
| 46-55 насны | 6,560 |
| 55-аас дээш | 3,912 |
| **Гишүүдийн боловсрол** | |
| Дээд | 10,682 |
| Тусгай дунд | 4,179 |
| Бүрэн дунд | 5,198 |
| Дунд | 3,412 |
| Бага | 1,245 |
| **Хадгаламж эзэмшигч гишүүдийн тоо** | |
| Хугацаатай | 6,879 |
| Хугацаагүй | 2,174 |
| Зээлдэгч гишүүдийн тоо | 10,915 |
| Хэвийн | 10,293 |
| Хугацаа хэтэрсэн | 406 |
| Чанаргүй: | 419 |
| Хэвийн бус | 153 |
| Эргэлзээтэй | 124 |
| Муу | 145 |
| **Бусад статистик мэдээлэл** | |
| Нийт ажилчдын тоо | 395 |
| Үүнээс: эмэгтэй | 285 |
| Компьютерийн тоо | 256 |
| Санхүүгийн программтай ХЗХ-дын тоо | 40 |

*-Статистик мэдээллийг 2013 оны гуравдугаар улирлаас зохистой харьцааны шалгуур үзүүлэлтийн тайлангийн хамт цахим хэлбэрээр хүлээн авч эхэлсэн.

## *2.2 Ерөнхий санхүүгийн үзүүлэлтүүд*

/мянган төгрөгөөр/

| д/д | Үндсэн үзүүлэлтүүд | 2012 оны IV улирал | 2013 оны IV улирал | Өөрчлөлт | |
|---|---|---|---|---|---|
| | | | | дүн | хувь |
| 1 | ХЗХ-дын тоо | **148** | **141** | (7) | -4.7 |
| 2 | Гишүүдийн тоо | **26,004** | **27,245** | 1,241 | 4.8 |
| 3 | Нийт актив | 67,715,372.3 | 73,836,256.6 | 6,120,884.2 | 9.0 |
| | ***Банкны салбарт эзлэх хувь*** | ***0.6%*** | ***0.4%*** | (0.0) | |
| 4 | Нийт зээлийн өрийн үлдэгдэл | 48,323,993.7 | 49,374,352.1 | 1,050,358.4 | 2.2 |
| | ***Банкны салбарт эзлэх хувь*** | ***0.7%*** | ***0.5%*** | (0.0) | |
| 5 | Нийт чанаргүй зээлийн үлдэгдэл | 1,061,317.1 | 1,545,393.8 | 484,076.7 | 45.6 |
| | ***Банкны салбарт эзлэх хувь*** | ***0.4%*** | ***0.3%*** | (0.4) | |
| 6 | Нийт татан төвлөрүүлсэн хадгаламжийн үлдэгдэл | 47,085,939.6 | 50,681,959.1 | 3,596,019.5 | 7.6 |
| | ***Банкны салбарт эзлэх хувь*** | ***1.1%*** | ***0.8%*** | (0.1) | |
| 7 | Нийт хувь хөрөнгийн үлдэгдэл | 9,441,815.2 | 9,786,928.9 | 345,113.7 | 3.7 |
| | ***Банкны салбарт эзлэх хувь*** | ***3.4%*** | * | | |
| 8 | Нийт хоршоологчдын өмчийн үлдэгдэл | 6,947,309.0 | 8,658,919.5 | 1,711,610.5 | 24.6 |
| 9 | Банк, ББСБ-аас авсан богино хугацаат зээлийн дүн | 968,120.3 | 417,588.9 | (550,531.4) | -56.9 |
| 10 | Банк, ББСБ-аас авсан урт хугацаат зээлийн дүн | 533,467.4 | 532,711.6 | (755.8) | -0.1 |
| 11 | Нийт орлого | 16,554,324.3 | 17,567,984.8 | 1,013,660.5 | 6.1 |
| 12 | Нийт зардал | 12,713,905.5 | 13,498,669.2 | 784,763.7 | 6.2 |
| 13 | Тухайн үеийн ашиг, алдагдал | 3,840,418.8 | 4,069,315.6 | 228,896.8 | 6.0 |

Тайлант улиралд ХЗХ-дод Банк болон ББСБ-аас авсан богино хугацаат зээлийн үлдэгдэл Улаанбаатар хотод үйл ажиллагаа эрхэлж буй 3 ХЗХ-нд 116,598.2 мянган төгрөг, орон нутагт үйл ажиллагаа эрхэлж буй 17 ХЗХ-нд 300,990.7 мянган төгрөг, салбарын хэмжээнд нийт 20 ХЗХ-нд 417,588.9 мянган төгрөг байгаа нь өмнөх оны мөн үеэс 550,531.4 мянган төгрөгөөр буурсан үзүүлэлттэй байна.

Хадгаламж, зээлийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөлтэй 141 ХЗХ-д байгаагийн 40.4 хувь буюу 57 ХЗХ нь Улаанбаатар хотод, 59.6 хувь буюу 84 ХЗХ нь орон нутагт үйл ажиллагаагаа явуулж байна. 2013 оны жилийн эцсийн байдлаарх 141 ХЗХ-дын орон нутгийн байршлыг үзүүлбэл:



## *2.3 Улаанбаатар хотод үйл ажиллагаа явуулж буй ХЗХ-дын статистик үзүүлэлтүүд*

/мянган төгрөгөөр/

| д/д | Үндсэн үзүүлэлтүүд | 2012 оны IV улирал | 2013 оны IV улирал | Өөрчлөлт | |
|---|---|---|---|---|---|
| | | | | дүн | хувь |
| 1 | УБ хотод үйл ажиллагаа явуулж буй ХЗХ-дын тоо | **64** | **57** | **(7)** | -10.9 |
| 2 | Гишүүдийн тоо | **11,884** | **11,721** | **(163)** | -1.4 |
| | ***ХЗХ-ны гишүүдийн нийт тоонд эзлэх хувь*** | **44.2%** | **43.0%** | **-1.2%** | |
| 3 | Нийт актив | 53,581,157.4 | 63,322,097.2 | 9,740,939.79 | 18.2 |
| | ***ХЗХ-ны нийт активт эзлэх хувь*** | **86.6%** | **85.8%** | **-0.8%** | |
| 4 | Нийт зээлийн өрийн үлдэгдэл | 34,899,154.2 | 41,419,014.8 | 6,519,860.61 | 18.7 |
| | ***ХЗХ-ны нийт зээлийн өрийн үлдэгдэлд эзлэх хувь*** | **84.1%** | **83.9%** | **-0.2%** | |
| 5 | Нийт чанаргүй зээлийн үлдэгдэл | 2,068,090.5 | 1,365,435.2 | (702,655.35) | -34.0 |
| | ***ХЗХ-ны нийт чанаргүй зээлийн үлдэгдэлд эзлэх хувь*** | **80.4%** | **88.4%** | **8.0%** | |
| 6 | Нийт татсан хадгаламжийн үлдэгдэл | 40,082,072.6 | 45,841,259.5 | 5,759,186.88 | 14.4 |
| | ***ХЗХ-ны нийт хадгаламжийн үлдэгдэлд эзлэх хувь*** | **91.4%** | **90.4%** | **-1.0%** | |
| 7 | Нийт хувь нийлүүлсэн хөрөнгө | 5,819,530.0 | 6,888,436.6 | 1,068,906.60 | 18.4 |
| | ***ХЗХ-ны нийт хувь хөрөнгийн үлдэгдэлд эзлэх хувь*** | **69.6%** | **70.4%** | **0.8%** | |
| 8 | Нийт хоршоологчдын өмчийн дүн | 3,888,877.9 | 7,138,057.5 | 3,249,179.64 | 83.6 |
| | ***ХЗХ-ны нийт хоршоологчдын өмчийн дүнд эзлэх хувь*** | **80.5%** | **82.4%** | **1.9%** | |
| 9 | Нийт банк, ББСБ-аас авсан БХ-Т зээлийн дүн | 1,005,322.1 | 116,598.2 | -888,723.95 | -88.4 |
| 10 | Банк, ББСБ-аас авсан урт хугацаат зээлийн дүн | 11,252.5 | 31,394.3 | 20,141.81 | 179.0 |
| 11 | Нийт орлого | 11,058,391.2 | 14,391,299.2 | 3,332,907.95 | 30.1 |
| 12 | Нийт зардал | 9,544,426.7 | 11,210,112.4 | 1,665,685.73 | 17.5 |
| 13 | Тухайн үеийн ашиг, алдагдал | 1,513,964.5 | 3,181,186.7 | 1,667,222.22 | 110.1 |

Улаанбаатар хотодүйл ажиллагаа явуулж буй 57 ХЗХ-дын нийт актив 63,322,097.2 мянган төгрөг байгаа нь салбарын нийт активын 85.8 хувийг, орлого 14,391,299.2 мянган төгрөг байгаа нь хадгаламж, зээлийн хоршоодын нийт орлогын 81.9 хувийг, зардал 11,210,112.4 мянган төгрөг байгаа нь хадгаламж, зээлийн хоршоодын нийт зардлын 8 3.0 хувийг тус тус эзэлж байна.

## *2.4 Орон нутагт үйл ажиллагаа явуулж буй ХЗХ-дын статистик үзүүлэлтүүд*

/мянган төгрөгөөр/

| д/д | Үндсэн үзүүлэлтүүд | 2012 оны IV улирал | 2013 оны IV улирал | Өөрчлөлт | |
|---|---|---|---|---|---|
| | | | | дүн | хувь |
| 1 | Орон нутагт үйл ажиллагаа явуулж буй ХЗХ-дын тоо | **84** | **84** | 0 | 0.0 |
| 2 | Гишүүдийн тоо | **14,527** | **15,524** | 997 | 6.9 |
| | ***ХЗХ-ны гишүүдийн нийт тоонд эзлэх хувь*** | **56.8%** | **57.0%** | ***0.2%*** | |
| 3 | Нийт актив | 9,366,879.8 | 10,514,159.4 | 1,147,279.6 | 12.2 |
| | ***ХЗХ-ны нийт активт эзлэх хувь*** | **13.8%** | **14.2%** | ***0.4%*** | |
| 4 | Нийт зээлийн өрийн үлдэгдэл | 6,845,045.6 | 7,955,337.3 | 1,110,291.7 | 16.2 |
| | ***ХЗХ-ны нийт зээлийн өрийн үлдэгдэлд эзлэх хувь*** | **14.2%** | **16.1%** | ***1.9%*** | |
| 5 | Нийт чанаргүй зээлийн үлдэгдэл | 140,498.4 | 179,958.6 | 39,460.2 | 28.1 |
| | ***ХЗХ-ны нийт чанаргүй зээлийн үлдэгдэлд эзлэх хувь*** | **13.2%** | **11.6%** | ***-1.6%*** | |
| 6 | Нийт татсан хадгаламжийн үлдэгдэл | 4,157,652.9 | 4,840,699.6 | 683,046.7 | 16.4 |
| | ***ХЗХ-ны нийт хадгаламжийн үлдэгдэлд эзлэх хувь*** | **8.8%** | **9.6%** | ***0.8%*** | |
| 7 | Нийт хувь нийлүүлсэн хөрөнгө | 2,837,691.1 | 2,898,492.3 | 60,801.2 | 2.1 |
| | ***ХЗХ-ны нийт хувь хөрөнгийн үлдэгдэлд эзлэх хувь*** | **30.1%** | **29.6%** | ***-0.5%*** | |

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| 8 | Нийт хоршоологчдын өмчийн дүн | 1,327,950.7 | 1,520,862.0 | 192,911.3 | 14.5 |
| | ***ХЗХ-ны нийт хоршоологчдын өмчийн дүнд эзлэх хувь*** | **19.1%** | **17.6%** | ***-1.5%*** | |
| 9 | Нийт банк, ББСБ-аас авсан богино хугацаат зээлийн дүн | 237,406.6 | 300,990.7 | 63,584.1 | 26.8 |
| 10 | Банк, ББСБ-аас авсан урт хугацаат зээлийн дүн | 443,758.0 | 501,317.3 | 57,559.3 | 13.0 |
| 11 | Нийт орлого | 2,818,227.2 | 3,176,685.6 | 358,458.4 | 12.7 |
| 12 | Нийт зардал | 1,970,357.2 | 2,288,556.7 | 318,199.5 | 16.1 |
| 13 | Тухайн үеийн ашиг | 847,870.1 | 888,128.9 | 40,258.8 | 4.7 |

Орон нутагт үйл ажиллагаа явуулж буй 84 ХЗХ-дын актив 10,514,159.4 мянган төгрөг байгаа нь нийт активын 14.2 хувийг, орлого 3,176,685.6 мянган төгрөг байгаа нь хадгаламж, зээлийн хоршоодын нийт орлогын 18.1 хувийг, зардал 2,288,556.7 мянган төгрөг байгаа нь хадгаламж, зээлийн хоршоодын нийт зардлын 17.0 хувийг тус тус эзэлж байна.

### *2.5 Хасбанкны франчайзын гэрээтэй ажиллаж буй ХЗХ-дын статистик үзүүлэлтүүд*

/мянган төгрөгөөр/

| д/д | Үндсэн үзүүлэлтүүд | 2012 оны IV улирал | 2013 оны IV улирал | Өөрчлөлт | |
|---|---|---|---|---|---|
| | | | | дүн | хувь |
| 1 | Хас банктай франчайзийн гэрээтэй ХЗХ-дын тоо | **49** | **49** | - | |
| 2 | Гишүүдийн тоо | **9,975** | **10,499** | ***524*** | 5.3 |
| | ***ХЗХ-ны гишүүдийн нийт тоонд эзлэх хувь*** | **38.4%** | **38.5%** | ***0.1%*** | |
| 3 | Нийт актив | 4,875,343.7 | 5,671,175.8 | 795,832.1 | 16.3 |
| | ***ХЗХ-ны нийт активт эзлэх хувь*** | **7.2%** | **7.7%** | ***0.5%*** | |
| 4 | Нийт зээлийн өрийн үлдэгдэл | 3,708,822.7 | 4,329,228.1 | 620,405.4 | 16.7 |
| | ***ХЗХ-ны нийт зээлийн өрийн үлдэгдэлд эзлэх хувь*** | **7.7%** | **8.8%** | ***1.1%*** | |
| 5 | Нийт чанаргүй зээлийн үлдэгдэл | 57,512.1 | 59,379.7 | 1,867.6 | 3.2 |
| | ***ХЗХ-ны нийт чанаргүй зээлийн үлдэгдэлд эзлэх хувь*** | **5.4%** | **3.8%** | ***-1.6%*** | |
| 6 | Нийт татсан хадгаламжийн үлдэгдэл | 1,589,353.9 | 2,156,771.0 | 567,417.1 | 35.7 |
| | ***ХЗХ-ны нийт хадгаламжийн үлдэгдэлд эзлэх хувь*** | **3.4%** | **4.3%** | ***0.9%*** | |
| 7 | Нийт хувь нийлүүлсэн хөрөнгө | 1,765,619.6 | 1,746,345.9 | -19,273.7 | -1.1 |
| | ***ХЗХ-ны нийт хувь хөрөнгийн үлдэгдэлд эзлэх хувь*** | **18.7%** | **17.8%** | ***-0.9%*** | |
| 8 | Нийт хоршоологчдын өмчийн дүн | 785,933.1 | 844,897.8 | 58,964.7 | 7.5 |
| | ***ХЗХ-ны нийт хоршоологчдын өмчийн дүнд эзлэх хувь*** | **11.3%** | **9.8%** | ***-1.5%*** | |
| 9 | Банк, ББСБ-аас авсан богино хугацаат зээлийн дүн | 237,406.6 | 287,790.7 | 50,384.1 | 21.2 |
| 10 | Банк, ББСБ-аас авсан урт хугацаат зээлийн дүн | 349,908.1 | 424,017.8 | 74,109.7 | 21.2 |
| 11 | Нийт орлого | 1,449,796.1 | 1,649,990.3 | 200,194.2 | 13.8 |
| 12 | Нийт зардал | 986,070.7 | 1,214,175.2 | 228,104.5 | 23.1 |
| 13 | Тухайн үеийн ашиг, алдагдал | 463,725.3 | 435,815.0 | - 27,910.3 | -6.0 |

## ГУРАВ. АКТИВЫН ЧАНАР, ЗЭЭЛИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТАЛААР

### *3.1 Активын чанар*

ХЗХ-дын жилийн эцсийн байдлаарх нийт активын бүтцийг өмнөх оны мөн үетэй харьцуулахад дараах байдалтай байна. Үүнд:

/мянган төгрөгөөр/

| ҮЗҮҮЛЭЛТ | 2012/12/31 | | 2013/12/31 | | Өөрчлөлт | |
|---|---|---|---|---|---|---|
| | Дүн | Хувь | Дүн | Хувь | Дүн | Хувь |
| ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГӨ | 66,088,769.2 | 97.6 | 71,728,011.8 | 97.1 | 5,639,242.6 | 8.5 |
| МӨНГӨН ХӨРӨНГӨ | 15,903,059.3 | 23.5 | 20,595,305.6 | 27.9 | 4,692,246.4 | 29.5 |

| | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|
| Касс дахь бэлэн мөнгө | 2,687,016.9 | 4.0 | 2,395,564.1 | 3.2 | (291,452.8) | -10.8 |
| Банкинд байршуулсан харилцах | 9,673,836.1 | 14.3 | 14,915,391.9 | 20.2 | 5,241,555.8 | 54.2 |
| Банкинд байршуулсан хадгаламж | 3,542,206.3 | 5.2 | 3,284,349.6 | 4.4 | (257,856.7) | -7.3 |
| ЗЭЭЛ (ЦЭВРЭЭР) | 47,653,909.0 | 70.4 | 48,507,413.7 | 65.7 | 853,504.7 | 1.8 |
| Нийт зээл | 48,323,993.7 | 71.4 | 49,374,352.1 | 66.9 | 1,050,358.4 | 2.2 |
| Хэвийн зээл | 46,002,848.5 | 67.9 | 46,610,672.7 | 63.1 | 607,824.2 | 1.3 |
| Хугацаа хэтэрсэн зээл | 1,259,828.1 | 1.9 | 1,218,285.6 | 1.6 | (41,542.5) | -3.3 |
| Чанаргүй зээл | 1,061,317.1 | 1.6 | 1,545,393.8 | 2.1 | 484,076.7 | 45.6 |
| *Хэвийн бус* | 291,337.0 | 0.4 | 472,197.7 | 0.6 | 180,860.6 | 62.1 |
| *Эргэлзээтэй зээл* | 444,699.6 | 0.7 | 779,616.4 | 1.1 | 334,916.8 | 75.3 |
| *Муу зээл* | 325,280.5 | 0.5 | 293,579.7 | 0.4 | (31,700.8) | -9.7 |
| (Зээлийн эрсдэлийн сан) | 670,084.7 | 1.0 | 866,938.4 | 1.2 | 196,853.7 | 29.4 |
| АВЛАГА (ЦЭВРЭЭР) | 1,852,288.8 | 2.7 | 1,858,865.9 | 2.5 | 6,577.1 | 0.4 |
| Байгууллага, хүмүүсээс авах авлага | 407,461.9 | 0.6 | 132,890.26 | 0.2 | (274,571.6) | -67.4 |
| (Байгууллага, хүмүүсээс авах авлагын эрсдлийн сан) | 30,235.3 | 0.0 | | 0.0 | (30,235.3) | -100.0 |
| Хуримтлуулж тооцсон хүүгийн авлага | 1,475,062.2 | 2.2 | 1,725,975.66 | 2.3 | 250,913.5 | 17.0 |
| БУСАД ХӨРӨНГӨ | 202,645.5 | 0.3 | 174,696.8 | 0.2 | (27,948.7) | -13.8 |
| Материал үнэ бүхий зүйл | 140,817.8 | 0.2 | 51,948.3 | 0.1 | (88,869.5) | -63.1 |
| Урьдчилж төлсөн зардал, тооцоо | 12,330.4 | 0.0 | 15,572.6 | 0.0 | 3,242.2 | 26.3 |
| Бусад актив | 49,497.4 | 0.1 | 107,175.9 | 0.1 | 57,678.6 | 116.5 |
| ӨБУСАД ҮЛ ХӨДЛӨХ ХӨРӨНГӨ (ЦЭВРЭЭР) | 476,866.7 | 0.7 | 591,729.8 | 0.8 | 114,863.1 | 24.1 |
| Өмчлөх бусад хөрөнгө | 516,417.4 | 0.8 | 594,886.1 | 0.8 | 78,468.6 | 15.2 |
| (Өмчлөх бусад хөрөнгийн эрсдлийн сан) | 39,550.7 | 0.1 | 3,156.2 | 0.0 | (36,394.5) | -92.0 |
| ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГӨ | 1,626,603.1 | 2.4 | 2,108,244.7 | 2.9 | 481,641.6 | 29.6 |
| ҮНДСЭН ХӨРӨНГӨ (ЦЭВРЭЭР) | 1,584,870.0 | 2.3 | 2,071,384.3 | 2.8 | 486,514.3 | 30.7 |
| Үндсэн хөрөнгө | 2,043,264.0 | 3.0 | 2,544,720.7 | 3.4 | 501,456.7 | 24.5 |
| ( Үндсэн хөрөнгийн элэгдэл) | 458,393.9 | 0.7 | 473,336.4 | 0.6 | 14,942.4 | 3.3 |
| БУСАД ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГӨ | 41,733.1 | 0.1 | 36,860.4 | 0.0 | (4,872.7) | -11.7 |
| Биет бус хөрөнгө | 14,627.8 | 0.0 | 6,820.4 | 0.0 | (7,807.4) | -53.4 |
| Бусад | 27,105.2 | 0.0 | 30,040.0 | 0.0 | 2,934.8 | 10.8 |
| НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН (1+2) | 67,715,372.3 | 100.0 | 73,836,256.6 | 100.0 | 6,120,884.2 | 9.0 |

Активын хэмжээ өмнөх оны мөн үетэй харьцуулахад 9.0 хувиар буюу 6,120,884.2 мянган төгрөгөөр өссөн. Энэ өсөлтөд эргэлтийн хөрөнгө тэр дундаа нийт зээлийн хэмжээ өмнөх оны мөн үетэй харьцуулахад 2.2 хувиар буюу 1,050,358.4 мянган төгрөгөөр, банкны харилцах 54.2 хувиар буюу 5,241,555.8 мянган төгрөгөөр тус тус өссөн нь нөлөөлсөн.

Салбарын хэмжээгээр нийт активын өсөлтийг графикаар харуулбал:




Активын төвлөрлийн байдлыг авч үзвэл дараах байдалтай байна. Үүнд:

/мянган төгрөгөөр/

| д/д | Активын хэмжээ | ХЗХ-дын тоо | Нийт актив | Нийт активт эзлэх хувь |
|---|---|---|---|---|
| 1 | 10,000,000.0 дээш | 1 | 31,751,973.5 | 43.0% |

| | | | | |
|---|---|---|---|---|
| 2 | 1,000,000.0-10,000,000.0 | 9 | 25,744,633.4 | 34.9% |
| 3 | 500,000.0-1,000,000.0 | 5 | 3,630,389.1 | 4.9% |
| 4 | 100,000.0-500,000.0 | 43 | 9,683,523.7 | 13.1% |
| 5 | 50,000.0-100,000.0 | 25 | 1,686,838.1 | 2.3% |
| 6 | 10,000.0-50,000.0 | 45 | 1,255,170.3 | 1.7% |
| 7 | 5,000.0-10,000.0 | 9 | 69,653.6 | 0.1% |
| 8 | 5,000.0 хүртэл | 4 | 14,074.9 | 0.0% |
| | **Нийт дүн** | **141** | **73,836,256.6** | **100.0%** |

ХЗХ-ны активын төвлөрлийг ангилахад томоохон буюу 1 тэрбум төгрөгөөс дээш актив хөрөнгөтэй 10 ХЗХ-ны нийт актив 57,496,606.9 мянган төгрөг байгаа нь нийт ХЗХ-дын активын 77.9 хувийг эзэлж байна.

### *3.2 Зээлийн үйл ажиллагааны талаар*

Зээлийн ангиллыг өмнөх оны мөн үетэй харьцуулахад дараах байдалтай байна. Үүнд:

/мянган төгрөгөөр/

| ҮЗҮҮЛЭЛТ | 2012/12/31 | хувь | 2013/12/31 | хувь | Өөрчлөлт | |
|---|---|---|---|---|---|---|
| ЗЭЭЛ (ЦЭВРЭЭР) | 47,653,909.0 | | 48,507,413.7 | | 853,504.7 | 1.8% |
| Нийт зээл | 48,323,993.7 | 100.0% | 49,374,352.1 | 100.0% | 1,050,358.4 | 2.2% |
| Хэвийн зээл | 46,002,848.5 | 95.2% | 46,610,672.7 | 94.4% | 607,824.2 | 1.3% |
| Хугацаа хэтэрсэн зээл | 1,259,828.1 | 2.6% | 1,218,285.6 | 2.5% | -41,542.5 | -3.3% |
| Чанаргүй зээл | 1,061,317.1 | 2.2% | 1,545,393.8 | 3.1% | 484,076.7 | 45.6% |
| *Хэвийн бус* | 291,337.0 | 0.6% | 472,197.7 | 1.0% | 180,860.6 | 62.1% |
| *Эргэлзээтэй зээл* | 444,699.6 | 0.9% | 779,616.4 | 1.6% | 334,916.8 | 75.3% |
| *Муу зээл* | 325,280.5 | 0.7% | 293,579.7 | 0.6% | -31,700.8 | -9.7% |
| (Зээлийн эрсдэлийн сан) | 670,084.7 | | 866,938.4 | | 196,853.7 | 29.4% |

Жилийн эцсийн байдлаар ХЗХ-дын нийт зээлийн багц 49,374,352.1 мянган төгрөг байгаа нь активын 66.9 хувьтай тэнцэж байна. Цэвэр зээлийнөрийн үлдэгдлийг өмнөх оны мөн үетэй харьцуулахад 853,504.7 мянган төгрөгөөр буюу 1.8 хувиар өссөн бол, чанаргүй зээлийн үлдэгдэл 484,076.7 мянган төгрөгөөр өссөн байна.

Нийт зээлийн багцад эзлэх чанаргүй зээлийн хэмжээ өмнөх оны мөн үетэй харьцуулахад 484,076.7 мянган төгрөгөөр, зээлийн болзошгүй эрсдэлийн сан 196,853.7 мянган төгрөгөөр тус тус өсч зээлийн багцын чанар муудсан үзүүлэлттэй байна.

ХЗХ-дын зээлийн өрийн үлдэгдлийг интервалаар харуулбал дараах байдалтай байна.

/мянган төгрөгөөр/

| д/д | Зээлийн хэмжээ /интервал/ | ХЗХ-дын тоо | Нийт зээлийн хэмжээ | Нийт зээлд эзлэх хувь |
|---|---|---|---|---|
| 1 | 10,000,000.0 дээш | 1 | 16,703,423.2 | 33.8% |
| 2 | 1,000,000.0-10,000,000.0 | 7 | 18,389,422.8 | 37.2% |
| 3 | 500,000.0-1,000,000.0 | 6 | 4,276,823.6 | 8.7% |
| 4 | 100,000.0-500,000.0 | 32 | 6,798,695.2 | 13.8% |
| 5 | 50,000.0-100,000.0 | 22 | 1,686,225.7 | 3.4% |
| 6 | 10,000.0-50,000.0 | 51 | 1,398,255.6 | 2.8% |
| 7 | 5,000.0-10,000.0 | 11 | 85,527.4 | 0.2% |
| 8 | 5,000.0 хүртэл | 11 | 35,978.7 | 0.1% |
| | **Нийт дүн** | **141** | **49,374,352.1** | **100.0%** |

Зээлийн өрийн үлдэгдлийг бүлэглэхэд 500,000.0 мянган төгрөгөөс дээш зээлийн өрийн үлдэгдэлтэй 14 ХЗХ-ны зээлийнөрийн үлдэгдэл 39,369,669.5 мянган төгрөг байгаа нь нийт ХЗХ-дын зээлийн өрийн үлдэгдлийн 79.7 хувийг эзэлж байна.

Зээлийн өрийн үлдэгдэл ихтэй ХЗХ-дын мэдээлэл дараах байдалтай байна.

/мянган төгрөгөөр/

| д/д | ХЗХ-ны нэр | Зээлийн дүн | Нийт зээлд эзлэх хувь |
|---|---|---|---|
| 1 | Номин юнион | 16,703,423.2 | 33.8% |
| 2 | Монкорд | 5,876,906.5 | 11.9% |
| 3 | Сидан | 4,442,156.3 | 9.0% |
| 4 | Май капитал | 2,589,820.3 | 5.2% |
| 5 | Алтан давалгаа | 1,946,324.0 | 3.9% |
| 6 | Мон сант алдар | 1,343,630.7 | 2.7% |
| 7 | Монум | 1,097,020.0 | 2.2% |
| 8 | Кредит юнион монгол | 1,093,565.0 | 2.2% |
| 9 | Эмпипи | 926,023.4 | 1.9% |
| 10 | Есөн дэлбээ | 888,463.1 | 1.8% |
| 11 | Арвайн үр | 716,947.8 | 1.5% |
| 12 | Цэнгэл хөгжил | 601,022.3 | 1.2% |
| 13 | Завхан нөхөрлөл | 594,335.0 | 1.2% |
| 14 | Финком | 550,032.0 | 1.1% |
| | **Дүн** | **39,369,669.5** | **79.7%** |
| | **Бусад 127 ХЗХ-ны зээлийн дүн** | **10,004,682.5** | **20.3%** |
| | **Нийт зээлийн дүн** | **49,374,352.1** | **100.0%** |

## ДӨРӨВ. ПАССИВЫН БҮТЭЦ, ХАДГАЛАМЖИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТАЛААР

### *4.1 Хадгаламжийн үйл ажиллагааны талаар*

Татан төвлөрүүлсэн хадгаламжийн хэмжээ нийт активын 6 8.6 хувийг эзэлж байгаа бөгөөд тэдгээрийг бүлэглэн харуулбал:

/мянган төгрөгөөр/

| д/д | Хадгаламжийн хэмжээ /интервалаар/ | ХЗХ-дын тоо | Хадгаламжийн дүн | Нийт хадгаламжид эзлэх хувь |
|---|---|---|---|---|
| 1 | 10,000,000.0 дээш | 1 | 24,590,220.0 | 48.5% |
| 2 | 1,000,000.0-10,000,000.0 | 4 | 15,027,107.5 | 29.6% |
| 3 | 500,000.0-1,000,000.0 | 7 | 5,038,899.9 | 9.9% |
| 4 | 100,000.0-500,000.0 | 18 | 3,695,064.3 | 7.3% |
| 5 | 50,000.0-100,000.0 | 19 | 1,243,084.0 | 2.5% |
| 6 | 10,000.0-50,000.0 | 42 | 979,391.7 | 1.9% |
| 7 | 5,000.0-10,000.0 | 6 | 39,801.9 | 0.1% |
| 8 | 5,000.0 хүртэл | 30 | 68,389.7 | 0.1% |
| 9 | Хадгаламжгүй | 14 | | 0.0% |
| | **Нийт хадгаламжийн дүн** | **141** | **50,681,959.1** | **100.0%** |

Татан төвлөрүүлсэн хадгаламжийн үлдэгдлийг ангилахад 500,000.0 мянган төгрөгөөс дээш хадгаламжийн үлдэгдэлтэй 12 ХЗХ-ны хадгаламжийн үлдэгдэл 44,656,227.4 мянган төгрөг байгаа нь нийт ХЗХ-дын хадгаламжийн үлдэгдлийн 88.1 хувийг эзэлж байна.

Хадгаламж татан төвлөрүүлээгүй 14 ХЗХ байгаа нь нийт ХЗХ-дын 9.9 хувийг эзэлж байгаа ба эдгээр нь зөвхөн өөрийн хөрөнгөөрөө үйл ажиллагаагаа явуулж байна.

Салбарын хэмжээгээр нийт хадгаламжийн өсөлтийг графикаар харуулбал:




## *4.2 Өр төлбөр ба өөрийн хөрөнгийн талаар*

Нийт өр төлбөр ба өөрийн хөрөнгийн бүтцийг өмнөх оны мөн үетэй харьцуулж үзвэл дараах байдалтай байна. Үүнд:

/мянган төгрөгөөр/

| ҮЗҮҮЛЭЛТ | 2012/12/31 | | 2013/12/31 | | Өөрчлөлт | |
|---|---|---|---|---|---|---|
| | Дүн | Хувь | Дүн | Дүн | Хувь | Дүн |
| ӨР ТӨЛБӨР | 51,326,248.2 | 75.8 | 54,814,301.2 | 74.2 | 3,488,053.0 | 6.8 |
| ХАДГАЛАМЖ | 47,085,939.6 | 69.5 | 50,681,959.1 | 68.6 | 3,596,019.5 | 7.6 |
| Хугацаагүй | 2,519,617.9 | 3.7 | 2,291,402.1 | 3.1 | -228,215.8 | -9.1 |
| Хугацаатай | 44,566,321.7 | 65.8 | 48,390,557.0 | 65.5 | 3,824,235.4 | 8.6 |
| БОГИНО ХУГАЦААТ ЗЭЭЛ | 968,120.3 | 1.4 | 417,588.9 | 0.6 | -550,531.4 | -56.9 |
| Банк, ББСБ-аас авсан богино хугацаат зээл | 938,120.3 | 1.4 | 386,488.9 | 0.5 | -551,631.4 | -58.8 |
| Богино хугацаат төслийн санхүүжилт | 30,000.0 | 0.0 | 31,100.0 | 0.0 | 1,100.0 | 0.0 |
| БУСАД БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР | 2,738,720.9 | 4.0 | 3,183,648.3 | 4.3 | 444,927.4 | 16.2 |
| Татварын төлөх өглөг | 86,944.9 | 0.1 | 120,161.7 | 0.2 | 33,216.8 | 38.2 |
| Хуримтлуулж тооцсон хүүгийн өглөг | 2,542,353.2 | 3.8 | 2,907,330.2 | 3.9 | 364,977.1 | 14.4 |
| Өглөг | 81,743.2 | 0.1 | 84,004.2 | 0.1 | 2,261.0 | 2.8 |
| Бусад пассив | 27,679.6 | 0.0 | 72,152.2 | 0.1 | 44,472.5 | 160.7 |
| УРТ ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР | 533,467.4 | 0.8 | 531,104.9 | 0.7 | - 2,362.5 | -0.4 |
| Банк, ББСБ-аас авсан урт хугацаат зээл | 371,208.0 | 0.5 | 375,327.3 | 0.5 | 4,119.3 | 1.1 |
| Урт хугацаат төслийн санхүүжилт | 162,259.4 | 0.2 | 155,777.6 | 0.2 | -6,481.8 | 0.0 |
| ӨӨРИЙН ХӨРӨНГӨ | 16,389,124.2 | 24.2 | 19,021,955.4 | 25.8 | 2,632,831.2 | 16.1 |
| ХУВЬ НИЙЛҮҮЛСЭН ХӨРӨНГӨ | 9,441,815.2 | 13.9 | 9,786,928.9 | 13.3 | 345,113.7 | 3.7 |
| Хувь нийлүүлсэн хөрөнгө | 9,441,815.2 | 13.9 | 9,786,928.9 | 13.3 | 345,113.7 | 3.7 |
| ХОРШООЛОГЧДЫН ӨМЧ | 6,947,309.0 | 10.3 | 9,235,026.5 | 12.5 | 2,287,717.5 | 32.9 |
| Нөөцийн сан | 2,138,687.7 | 3.2 | 2,244,240.0 | 3.0 | 105,552.2 | 4.9 |
| Дахин үнэлгээний сан | 387,864.1 | 0.6 | 576,107.0 | 0.8 | 188,242.9 | 48.5 |
| Нийгмийн хөгжлийн сан | 311,113.3 | 0.5 | 363,970.8 | 0.5 | 52,857.5 | 17.0 |
| Бусад сангууд | 165,323.7 | 0.2 | 484,434.6 | 0.7 | 319,110.9 | 193.0 |
| Хандив, тусламж | 42,088.8 | 0.1 | 13,941.3 | 0.0 | - 28,147.5 | -66.9 |
| Хадгаламж хамгаалалтын сан | | | 6,239.1 | | | |
| Бусад өмч | 34,260.3 | 0.1 | | 0.0 | -34,260.3 | -100.0 |

| | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|
| Тайлангийн үеийн ашиг/алдагдал | 3,840,418.8 | 5.7 | 4,069,315.6 | 5.5 | 228,896.8 | 6.0 |
| Хуримтлагдсан ашиг/алдагдал | 27,552.4 | 0.0 | 1,476,778.1 | 2.0 | 1,449,225.7 | 5259.9 |
| ӨР ТӨЛБӨР БА ӨӨРИЙН ХӨРӨНГӨ ДҮН (1+2) | 67,715,372.3 | 100.0 | 73,836,256.6 | 100.0 | 6,120,884.2 | 9.0 |

ХЗХ-дын өр төлбөр, өөрийн хөрөнгийн хэмжээ буюу эх үүсвэр өмнөх оны мөн үетэй харьцуулахад 6,120,884.2 мянган төгрөгөөр өссөн. Энэ өсөлтөд хадгаламжийн хэмжээ 3,596,019.5 мянган төгрөгөөр, хувь хөрөнгө 345,113.7 мянган төгрөгөөр, хоршоологчдын өмч 2,287,717.5 мянган төгрөгөөр тус тус өссөн нь нөлөөлсөн байна.

### *4.3 Хувь хөрөнгийн талаар*

Тайлант улирлын байдлаар хувь хөрөнгийн хэмжээ 9, 786,928.9 мянган төгрөг байгаа нь нийт активын 13.3 хувийг эзэлж байна. Үүнийг интервалаар харуулбал:

/мянган төгрөгөөр/

| д/д | Хувь нийлүүлсэн хөрөнгийн хэмжээ /интервалаар/ | ХЗХ-дын тоо | Хувь нийлүүлсэн хөрөнгийн дүн | Нийт хувь нийлүүлсэн хөрөнгөнд эзлэх хувь |
|---|---|---|---|---|
| 1 | 2,000,000.0 дээш | 1 | 2,062,235.2 | 21.1% |
| 2 | 500,000.0-1,000,000.0 | 2 | 1,703,202.0 | 17.4% |
| 3 | 100,000.0-500,000.0 | 17 | 2,774,014.6 | 28.3% |
| 4 | 50,000.0-100,000.0 | 21 | 1,420,077.3 | 14.5% |
| 5 | 15,000.0-50,000.0 | 52 | 1,488,107.5 | 15.2% |
| 6 | 10,000.0-15,000.0 | 11 | 129,163.4 | 1.3% |
| 7 | 5,000.0-10,000.0 | 22 | 162,874.7 | 1.7% |
| 8 | 5,000.0 хүртэл | 15 | 47,254.3 | 0.5% |
| | **Хувь нийлүүлсэн хөрөнгийн дүн** | **141** | **9,786,928.9** | **100.0%** |

150,000.0 мянган төгрөгөөс дээш хувь хөрөнгөтэй 10 ХЗХ-д дараах байдалтай байна:

/мянган төгрөгөөр/

| д/д | ХЗХ-ны нэр | Хувь хөрөнгийн дүн | Хувь хөрөнгөнд эзлэх хувь |
|---|---|---|---|
| 1 | Номин юнион | 2,062,235.2 | 21.1% |
| 2 | Май капитал | 928,089.7 | 9.5% |
| 3 | Монум | 775,112.3 | 7.9% |
| 4 | Монкорд | 409,928.8 | 4.2% |
| 5 | Сидан | 306,796.0 | 3.1% |
| 6 | Монконкорд | 241,880.1 | 2.5% |
| 7 | Ирээдүйн зорилт | 212,530.3 | 2.2% |
| 8 | Есөн дэлбээ | 177,712.8 | 1.8% |
| 9 | Билүү хөгжил | 152,248.0 | 1.6% |
| 10 | Цэнгэл хөгжил | 150,276.8 | 1.5% |
| | **Дүн** | **5,416,809.9** | **55.3%** |
| | **Бусад 131 ХЗХ-ны хувь хөрөнгийн дүн** | **4,370,119.1** | **44.7%** |
| | **Нийт хувь хөрөнгийн дүн** | **9,786,928.9** | **100.0%** |

ХЗХ-дын хувь хөрөнгийн өсөлт дараах байдалтай байна.




## *4.4 Өөрийн хөрөнгө, хоршоологчдын өмчийн талаар*

2013 оны жилийн эцсийн байдлаар ХЗХ-дын өөрийн хөрөнгө өмнөх оны мөн үеэс 2,632,831.2 мянган төгрөгөөр өсч 19 ,021,955.4 мянган төгрөгт хүрсэн. Үүнийг интервалаар харуулбал дараах байдалтай байна.

/мянган төгрөгөөр/

| д/д | Өөрийн хөрөнгийн хэмжээ /интервалаар/ | ХЗХ-дын нэр | Өөрийн хөрөнгийн дүн | Нийт өөрийн хөрөнгөнд эзлэх хувь |
|---|---|---|---|---|
| **1** | 2,000,000.0 дээш | 1 | 5,542,459.2 | 29.1% |
| **2** | 500,000.0-1,000,000.0 | 6 | 5,502,327.1 | 28.9% |
| **3** | 100,000.0-500,000.0 | 21 | 4,095,903.6 | 21.5% |
| **4** | 50,000.0-100,000.0 | 26 | 1,913,710.0 | 10.1% |
| **5** | 10,000.0-50,000.0 | 61 | 1,797,419.3 | 9.4% |
| **6** | 1,000.0-10,000.0 | 26 | 170,136.2 | 0.9% |
| | **Нийт өөрийн хөрөнгийн дүн** | **141** | **19,021,955.4** | **100.0%** |

Өр төлбөрийн хэмжээ нь активаас хэтэрсэн буюу өрийн хөрөнгөгүй болсон ХЗХ байхгүй. ХЗХ-дын хоршоологчдын өмчийн байдлыг интервалаар харуулбал:

/мянган төгрөгөөр/

| д/д | Хоршоологчдын өмчийн дүн /интервалаар/ | ХЗХ-дын тоо | Хоршоологчдын өмчийн дүн | Нийт хоршоологчдын өмчид эзлэх хувь |
|---|---|---|---|---|
| **1** | 500,000.0 дээш | 2 | 4,089,524.9 | 47.2% |
| **2** | 100,000.0-500,000.0 | 11 | 2,635,628.7 | 30.4% |
| **3** | 50,000.0-100,000.0 | 11 | 758,198.5 | 8.8% |
| **4** | 15,000.0-50,000.0 | 31 | 851,968.5 | 9.8% |
| **5** | 10,000.0-15,000.0 | 16 | 196,675.3 | 2.3% |
| **6** | 1,000.0-10,000.0 | 51 | 247,438.5 | 2.9% |
| **7** | 1,000.0 хүртэл | 7 | 3,310.9 | 0.0% |
| **8** | Хоршоологчдын өмчгүй /алдагдалтай/ | 12 | -123,825.9 | -1.4% |
| | **Нийт дүн** | **141** | **8,658,919.5** | **100.0%** |

# ТАВ. ОРЛОГО, ЗАРДАЛ, АШИГТ АЖИЛЛАГААНЫ ТАЛААР

## *5.1 ХЗХ-дын орлогын үзүүлэлтүүд*

Орлогын бүтцийг хүснэгтээр харуулбал дараах байдалтай байна. Үүнд:

/мянган төгрөгөөр/

| ҮЗҮҮЛЭЛТ | 2012/12/31 | | 2013/12/31 | | Өөрчлөлт | |
|---|---|---|---|---|---|---|
| | дүн | хувь | дүн | хувь | дүн | хувь |
| **ХҮҮГИЙН ОРЛОГО** | **15,426,045.5** | **93.2** | **16,862,274.1** | 96.0 | **1,436,228.7** | 9.3 |
| Хугацаандаа байгаа зээлийн хүүгийн орлого | 14,787,688.8 | 89.3 | 16,158,407.9 | 92.0 | 1,370,719.1 | 9.3 |
| Зээлийн нэмэгдүүлсэн хүү, алдангийн орлого | 222,871.7 | 1.3 | 184,635.0 | 1.1 | -38,236.7 | -17.2 |
| Банкнаас авсан харилцах, хадгаламжийн хүүгийн орлого | 366,772.0 | 2.2 | 504,495.7 | 2.9 | 137,723.8 | 37.6 |
| Бусад байгууллагаас авсан хүүгийн орлого | 39,932.9 | 0.2 | 14,703.5 | 0.1 | - 25,229.3 | -63.2 |
| Бусад хүүгийн орлого | 8,780.2 | 0.1 | 32.0 | 0.0 | -8,748.2 | -99.6 |
| **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУСАД ОРЛОГО** | **746,874.0** | **4.5** | **258,726.4** | 1.5 | **- 488,147.6** | -65.4 |
| Элсэлтийн хураамж | 9,973.2 | 0.1 | 15,583.0 | 0.1 | 5,609.9 | 56.2 |
| Гишүүний татвар | 24,536.4 | 0.1 | 18,038.0 | 0.1 | -6,498.4 | -26.5 |
| Үйлчилгээний хураамж | 154,976.9 | 0.9 | 185,906.8 | 1.1 | 30,929.9 | 20.0 |
| Үйл ажиллагааны бусад орлого | 557,387.6 | 3.4 | 18,854.6 | 0.1 | -538,532.9 | -96.6 |
| Санхүүгийн бусад ажил, үйлчилгээний орлого | | | 20,343.9 | 0.1 | | |
| **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ОРЛОГО** | **381,404.8** | **2.3** | **446,984.2** | 2.5 | **65,579.4** | 17.2 |
| Торгуулийн орлого | 130.0 | 0.0 | 9,954.3 | 0.1 | 9,824.3 | 7557.2 |
| Үндсэн хөрөнгийн түрээс, борлуулалтын орлого | 48,253.0 | 0.3 | 7,076.2 | 0.0 | -41,176.8 | -85.3 |
| ӨБҮХХ борлуулснаар олсон орлого | - | 0.0 | | 0.0 | - | - |
| Гадаад валютын ханшийн тэгшитгэлийн орлого | 20,879.8 | 0.1 | 2,731.4 | 0.0 | -18,148.4 | -86.9 |
| Тэнцлийн гадуурх тооцооноос орсон орлого | 76,267.8 | 0.5 | | 0.0 | -76,267.8 | -100.0 |
| Бусад орлого | 164,033.3 | 1.0 | 427,222.3 | 2.4 | 263,188.9 | 160.4 |
| Онцгой шинжтэй орлого | 66,428.6 | 0.4 | | 0.0 | -66,428.6 | -100.0 |
| Ердийн бус орлого | 5,412.2 | 0.0 | | 0.0 | -5,412.2 | |
| НИЙТ ОРЛОГЫН ДҮН | 16,554,324.3 | 100.0 | 17,567,984.8 | 100.0 | 1,013,660.5 | 6.1 |

2013 оны жилийн эцсийн байдлаар ХЗХ-дын нийт орлого 17,567,984.8 мянган төгрөг байгаа нь өмнөх оны мөн үетэй харьцуулахад 1,013,660.5 мянган төгрөгөөр буюу 6.1 хувиар өссөн. Энэ нь зээлийн хүүгийн орлого 1,436,228.7 мянган төгрөгөөр өсч, үйл ажиллаганы бус орлого 65,579.4 мянган төгрөгөөр тус тус өссөнтэй холбоотой байна.

## *5.2 ХЗХ-дын зардлын үзүүлэлтүүд*

Зардлын бүтцийг хүснэгтээр харуулбал дараах байдалтай байна. Үүнд:

/мянган төгрөгөөр/

| ҮЗҮҮЛЭЛТ | 2012/12/31 | | 2013/12/31 | | Өөрчлөлт | |
|---|---|---|---|---|---|---|
| | дүн | хувь | дүн | | дүн | хувь |
| **ХҮҮГИЙН ЗАРДАЛ** | **8,322,611.9** | **65.5** | **8,909,767.8** | 66.0 | **587,155.9** | 7.1 |
| Хугацаагүй хадгаламжийн хүүгийн зардал | 5,623,978.3 | 44.2 | 8,740,177.2 | 64.7 | 3,116,198.9 | 55.4 |
| Хугацаатай хадгаламжийн хүүгийн зардал (1 жил хүртэлх) | 2,324,402.8 | 18.3 | | 0.0 | -2,324,402.8 | -100.0 |
| Хугацаатай хадгаламжийн хүүгийн зардал (1-ээс дээш жил) | 193,961.2 | 1.5 | | 0.0 | -193,961.2 | -100.0 |
| Банк, санхүүгийн байгууллагад төлсөн хүүгийн зардал | 156,229.3 | 1.2 | 168,160.3 | 1.2 | 11,931.0 | 7.6 |
| Бусад хүүгийн зардал | 24,040.3 | 0.2 | 1,430.3 | 0.0 | -22,610.0 | -94.1 |
| **БОЛЗОШГҮЙ ЭРСДЭЛИЙН САНГИЙН ЗАРДАЛ** | **290,322.0** | **2.3** | **636,125.8** | 4.7 | **345,803.7** | 119.1 |

| | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|
| Зээлийн болзошгүй эрсдэлийн зардал | 279,917.2 | 2.2 | 632,668.0 | 4.7 | 352,750.8 | 126.0 |
| Авлагын болзошгүй эрсдэлийн зардал | 8,572.2 | 0.1 | 3,457.7 | 0.0 | -5,114.5 | -59.7 |
| ӨБҮХ-ийн үнэлгээний хасагдуулгын зардал | 431.3 | 0.0 | | 0.0 | -431.3 | -100.0 |
| Бусад эрсдэлийн зардал | 1,401.4 | 0.0 | | 0.0 | -1,401.4 | -00.0 |
| **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДАЛ** | **3,008,116.2** | **23.7** | **3,436,029.2** | 25.5 | **427,913.1** | 14.2 |
| **Боловсон хүчний зардал** | 1,972,313.9 | **15.5** | **2,286,435.7** | 16.9 | **314,121.8** | 15.9 |
| **Бусад зардал** | 1,035,802.3 | **8.1** | **1,149,593.5** | 8.5 | **113,791.2** | 11.0 |
| **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДАЛ** | **1,092,855.4** | **8.6** | **516,746.4** | 3.8 | **- 576,109.0** | -52.7 |
| Торгуулийн зардал | 13,567.3 | 0.1 | 7,709.0 | 0.1 | -5,858.3 | -43.2 |
| Ногдол ашгийн зардал | 61,391.1 | 0.5 | | 0.0 | -61,391.1 | |
| Үндсэн хөрөнгийн түрээс, борлуулалтын гарз | 2,447.1 | 0.0 | 77.7 | 0.0 | -2,369.5 | -96.8 |
| Гадаад валютын ханшийн тэгшитгэлийн зардал | 28,483.3 | 0.2 | 1,024.8 | 0.0 | -27,458.5 | -96.4 |
| Үйл ажиллагааны бус бусад зардал | 473,027.8 | 3.7 | 47,654.9 | 0.4 | -425,372.9 | -89.9 |
| Ердийн бус зардал | 26,243.2 | 0.2 | | 0.0 | -26,243.2 | -100.0 |
| Татварын зардал | 487,695.6 | 3.8 | 460,280.0 | 3.4 | - 27,415.5 | -5.6 |
| **НИЙТ ЗАРДЛЫН ДҮН** | **12,713,905.5** | **100.0** | **13,498,669.2** | **100.0** | **784,763.7** | **6.2** |

Тайлант жилд ХЗХ-дын нийт зардлын хэмжээ 13,498,669.2 мянган төгрөг байгаа нь өмнөх оны мөн үетэй харьцуулахад 784,763.7 мянган төгрөгөөр буюу 6.2 хувиар өсчээ. Үүнд хадгаламжийн хүүгийн зардал 587,155.9 мянган төгрөгөөр, болзошгүй эрсдэлийн сангийн зардал 345,803.7 мянган төгрөгөөр, үйл ажиллагааны зардал 427,913.1 мянган төгрөгөөр тус тус өссөн, харин үйл ажиллагааны бус зардал 576,109.0 мянган төгрөгөөр буурсан үзүүлэлтүүд нөлөөлсөн байна.

### *5.3 Алдагдалтай ажиллаж буй ХЗХ-д*

Нийт 141 ХЗХ-дын 8.5 хувь буюу 12 ХЗХ тайлант улиралд 58,922.3 мянган төгрөгийн алдагдалтай ажилласан байна. Үүнд:

/мянган төгрөгөөр/

| д/д | Алдагдлын хэмжээ /интервалаар/ | ХЗХ-дын тоо | Алдагдлын хэмжээ | Нийт алдагдалд эзлэх хувь |
|---|---|---|---|---|
| **1** | 5,000.0 мянган төгрөгөөс дээш | 3 | (40,856.1) | 69.3% |
| **2** | 1,000.0-5,000.0 мянган төгрөг хүртэл | 7 | (17,598.6) | 29.9% |
| **3** | 100.0-500.0 мянган төгрөг хүртэл | 1 | (432.6) | 0.7% |
| **4** | 100.0 мянган төгрөг хүртэл | 1 | (35.1) | 0.1% |
| | **Нийт дүн** | **12** | **(58,922.3)** | **100.0%** |

ХЗХ-дын нийт активт эзлэх алдагдлын түвшин 0.1 хувь байна. Энэ нь өнгөрсөн оны мөн үеийн үзүүлэлтээс 397,119.0 мянган төгрөгөөр өссөн үзүүлэлттэй байна.

Алдагдалтай ажиллаж байгаа ХЗХ-дын 8 нь Улаанбаатар хотод үйл ажиллагаа эрхэлдэг ба тэдгээрийн алдагдлын хэмжээ 44,499.7 мянган төгрөг байгаа нь ХЗХ-дын нийт алдагдлын 75.5 хувийг эзэлж байна.

Орон нутагт үйл ажиллагаа явуулж буй 4 ХЗХ тайлант улиралд 14,422.6 мянган төгрөгийн алдагдалтай ажилласан нь ХЗХ-дын нийт алдагдлын 24.5 хувийг эзэлж байна. Үүний дотор Хасбанктай франчайзын гэрээтэй 3 ХЗХ-ны 6,641.5 мянган төгрөгийн алдагдал нь орон нутагт хадгаламж, зээлийн үйл ажиллагаа эрхэлж буй алдагдалтай ажилласан ХЗХ-дын алдагдлын 46.0 хувийг, ХЗХ-дын нийт алдагдлын 11.3 хувийг тус тус эзэлж байна.

Алдагдалтай ажилласан ХЗХ-дын хувьд алдагдалтай ажиллахад нөлөөлсөн хүчин зүйлсийг тодруулж үзэхэд хамгийн их алдагдалтай ажилласан Чаданхүү, Грави ХЗХ-дын хувьд зээлийн чанар муудсан, зээлийг төлүүлэх талаар шүүхийн шийдвэр гарсан болович шийдвэр гүйцэтгэлийн явц удаашралтай байгаа зэргээс шалтгаалан төлбөрийн чадвар муудаж, алдагдалтай ажиллаж байна. Бусад ХЗХ-дын хувьд цалингийн зардал, түрээсийн зардал, зээл, авлагыг барагдуулахтай холбоотой зардал зэрэг үйл ажиллагааны зардлын хэмжээ үйл ажиллагааны орлогоос хэтэрсэн, зээлийн эрсдэлийн сангийн зардал өссөн зэргээс шалтгаалан алдагдалтай ажилласан байна.

Хэлтсийн зүгээс алдагдалтай ажилласан 12 ХЗХ-доос Завхан аймгийн Нугын дэвшил, Улаанбаатар хотын Гэрэг инвест, Хамтын хөгжлийн чуулган зэрэг 3 ХЗХ-дын хадгаламж, зээлийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрлийг хүчингүй болгосон, Жамба нинж ХЗХ-ны хадгаламж, зээлийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрлийг 3 сарын хугацаатайгаар түдгэлзүүлсэн арга хэмжээ авсан. Бусад нэр бүхий 8 ХЗХ-дын үйл ажиллагаанд зайнаас хяналт тавин ажиллаж байна.

### *5.4 Ашигтай ажиллаж буй ХЗХ-д*

Салбарын хэмжээнд тайлант жилд 4,128,237.9 мянган төгрөгийн ашигтай ажилласан ба ашгийн түвшин 5.6 хувь байгаа хэдий ч өмнөх оны мөн үеэс 228,896.8 мянган төгрөгөөр өссөн үзүүлэлттэй байна.

/мянган төгрөгөөр/

| д/д | Ашгийн хэмжээ /интервалаар/ | ХЗХ-дын тоо | Ашгийн хэмжээ | Нийт ашигт эзлэх хувь |
|---|---|---|---|---|
| **1** | 100,000.0 мянган төгрөгөөс дээш | 8 | 2,790,981.1 | 67.6% |
| **2** | 50,000.0-100,000.0 мянган төгрөг хүртэл | 4 | 296,366.4 | 7.2% |
| **3** | 10,000.0-50,000.0 мянган төгрөг хүртэл | 34 | 796,993.9 | 19.3% |
| **4** | 5,000.0-10,000.0 мянган төгрөг хүртэл | 18 | 121,667.9 | 2.9% |
| **5** | 1,000.0-5,000 мянган төгрөг хүртэл | 43 | 113,752.2 | 2.8% |
| **6** | 1,000.0 мянган төгрөг хүртэл | 22 | 8,476.5 | 0.2% |
| | **Нийт дүн** | **129** | **4,128,237.9** | **100.0%** |

Улаанбаатар хотод үйл ажиллагаа эрхэлж буй 49 ХЗХ тайлант жилд 3,225,686.4 мянган төгрөгийн ашигтай ажилласан нь ХЗХ-дын нийт ашгийн 78.1 хувийг эзэлж байна.

Харин орон нутагт үйл ажиллагаа явуулж буй 80 ХЗХ тайлант жилд 902,551.5 мянган төгрөгийн ашигтай ажилласан нь ХЗХ-дын нийт ашгийн 21.9 хувийг, Хасбанктай франчайзын гэрээтэй 46 ХЗХ нийт 445,102.5 мянган төгрөгийн ашигтай ажилласан нь орон нутагт үйл ажиллагаа эрхэлж буй ашигтай ажилласан ХЗХ-дын нийт ашгийн 49.3 хувийг тус тус эзэлж байна.

## ЗУРГАА. ХАДГАЛАМЖ, ЗЭЭЛИЙН ХОРШООДЫГ АКТИВААР БҮЛЭГЛЭСЭН ТАЛААР

Хорооноос ХЗХ-дод хийж буй газар дээрх шалгалтыг үр өгөөжтэй зохион байгуулах, чанаржуулах, нэг бүлэгт хамаарагдаж буй ХЗХ-дыг харьцуулах замаар тэдгээрийн санхүү, төлбөрийн чадварын байдалд бодит үнэлгээ өгөх зорилгоор активын хэмжээгээр нь 4 ангилж бүлэглэвэл:

| Бүлгийн дугаар | Бүлэглэсэн активын интервал | Бүлэгт багтах ХЗХ-н тоо | ХЗХ-нд эзлэх хувь | Нийт актив эзлэх хувь | Үүнээс | |
|---|---|---|---|---|---|---|
| | | | | | УБ хотод үйл ажиллагаа явуулж буй ХЗХ-ын тоо | Орон нутагт үйл ажиллагаа явуулж буй ХЗХ-ын тоо |
| **Бүлэг-1** | 50.0 сая төгрөг хүртэл | 58 | 41.1% | 1.8% | 17 | 41 |
| **Бүлэг-2** | 50-500.0 сая төгрөг | 68 | 48.3% | 15.4% | 29 | 39 |
| **Бүлэг-3** | 500.0-1.0 тэрбум төгрөг | 5 | 3.5% | 4.9% | 2 | 3 |
| **Бүлэг-4** | 1.0 тэрбумаас дээш | 10 | 7.1% | 77.9% | 9 | 1 |
| | **Нийт дүн** | **141** | **100.0%** | **100.0%** | **57** | **84** |

## ДОЛОО. ЗОХИСТОЙ ХАРЬЦААНЫ ШАЛГУУР ҮЗҮҮЛЭЛТҮҮДИЙН ТАЛААР

ХЗХ-дын санхүүгийн тайлангийн нэгтгэлээр хувьд Хорооны 2013 оны 79 дүгээр тогтоолоор тус тус нэмэлт өөрчлөлт орсон “Хадгаламж, зээлийн хоршооны үйл ажиллагааны зохистой харьцааны шалгуур үзүүлэлтийг тооцож, хяналт тавих журам”-аар тогтоосон зохистой харьцааны үзүүлэлтүүд дараах байдалтай байна. Үүнд:

| | ЗОХИСТОЙ ҮЗҮҮЛЭЛТҮҮД | БАЙВАЛ ЗОХИХ | ТАЙЛАНГААР |
|---|---|---|---|
| А | АКТИВЫН ЧАНАРЫН БОЛОН ХАМГААЛАЛТЫН ҮЗҮҮЛЭЛТИЙН ТАЙЛАН | | |
| 1 | АКТИВЫН ЭРСДЭЛИЙН САНГИЙН ХҮРЭЛЦЭЭ (+илүү, -дутуу) /мянган төгрөгөөр/ | 862,351.6 | 866,938.4 |
| 2 | ЧАНАРГҮЙ ЗЭЭЛИЙН ЗОХИСТОЙ ҮЗҮҮЛЭЛТ | 5.00%-иас бага | 3.1% |
| 3 | ЗЭЭЛИЙН ТӨВЛӨРЛИЙН ЭРСДЭЛИЙН ҮЗҮҮЛЭЛТ | 30.00%--иас бага | Тооцох боломжгүй |
| 4 | НЭГДМЭЛ СОНИРХОЛТОЙ ЭТГЭЭДЭД ОЛГОСОН ЗЭЭЛИЙН ЗОХИСТОЙ ХАРЬЦАА | 30.00%--иас бага | Тооцох боломжгүй |
| Б | ҮР АШИГТАЙ САНХҮҮГИЙН БҮТЦИЙН ҮЗҮҮЛЭЛТ | | |
| 5 | НИЙТ АКТИВ ХӨРӨНГӨД ЭЗЛЭХ ЗЭЭЛИЙН ХЭМЖЭЭ | 60%-80% хүртэл | 66.9% |
| 6 | ӨБҮХХ-ИЙН ЗОХИСТОЙ ХАРЬЦАА | 5.00% -иас бага | 0.8% |
| 7 | ҮНДСЭН ХӨРӨНГИЙН ЗОХИСТОЙ ХАРЬЦАА | 10.00%-иас бага | 2.8% |
| 8 | ГИШҮҮДИЙН ХАДГАЛАМЖИЙН ЗОХИСТОЙ ХАРЬЦАА | 80.00%-иас бага | 68.6% |
| 9 | БУСДААС АВСАН ЗЭЭЛИЙН ЗОХИСТОЙ ХАРЬЦАА | 20.00%-иас бага | 1.3% |
| 10 | ГИШҮҮДИЙН НИЙТ ХУВЬ ХӨРӨНГИЙН ЗОХИСТОЙ ХАРЬЦАА | 5.00%-иас их | 13.3% |
| 11 | НЭГ ГИШҮҮНИЙ ОРУУЛЖ БОЛОХ ХУВЬ ХӨРӨНГИЙН ЗОХИСТОЙ ХАРЬЦАА | 10.00%-иас бага | Тооцох боломжгүй |
| 12 | НӨӨЦИЙН САНГИЙН БАЙВАЛ ЗОХИХ ДООД ХЭМЖЭЭ /мянган төгрөг/ | 1,298,837.9 | 2,244,240.0 |
| В | ЗАРДЛЫН ЗОХИСТОЙ ХЭМЖЭЭ | | |
| 13 | ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ЗОХИСТОЙ ТҮВШИН | 15.00%-иас бага | 4.7% |
| Г | ТӨЛБӨР ТҮРГЭН ГҮЙЦЭТГЭХ ЧАДВАР | | |
| 14 | ТӨЛБӨР ТҮРГЭН ГҮЙЦЭТГЭХ ЧАДВАРЫН ХАРЬЦАА | 5.00%-иас их | 35.9% |
| Д | ӨГӨӨЖ, ЗАРДЛЫН ХУВЬ ХЭМЖЭЭ (ДОТООД ҮЙЛ АЖИЛЛАГААГ ДҮГНЭХ ҮЗҮҮЛЭЛТ) | | |
| 15 | АКТИВЫН ӨГӨӨЖ | | 6.4% |

ХЗХ-дын санхүүгийн тайлангийн нэгтгэлээр шалгуур үзүүлэлтүүдийг салбарын хэмжээгээр хангаж ажилласан байна. Тайлант улирлын байдлаар Хорооноос журмаар тогтоосон зохистой харьцааны шалгуур үзүүлэлтийг 16 ХЗХ бүрэн хангаж ажилласан, 116 ХЗХ 1-4 үзүүлэлтийг хангаж ажиллаагүй, 9 ХЗХ 5-7 үзүүлэлтийг хангаж ажиллаагүй үзүүлэлттэй байна.

## НАЙМ. ДҮГНЭЛТ, ЦААШИД АВАХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТАЛААР

ХЗХ-доос санхүүгийн болон зохистой харьцааны шалгуур үзүүлэлтийн тайланг улирал бүр хүлээн авч зайны хяналтыг хэрэгжүүлэх явцад 2013 оны 3 дугаар улирлаас эхлэн статистик мэдээллийг шинээр авч нэгтгэдэг болсон нь санхүүгийн тоон мэдээлэлд дүн шинжилгээ хийхээс гадна зайлшгүй шаардлагатай бусад мэдээллийг нэгтгэж үзэх, дүгнэлт хийх боломжтой болсон.

Мөн санхүүгийн тайлангийн нэтгэлд тайланг хамруулж буй байдлыг сүүлийн 3 жилийн байдлаар авч үзвэл 2011 онд 93.8 хувь, 2012 онд 96.0 хувь, 2013 онд 97.2 хувийн ирцтэйгээр нэгтгэж байгаа нь санхүүгийн тоон мэдээллийг үнэн бодитой гаргаж, мэдээллийг ашиглах боломжийг өрдүүлж байгаас гадна тайлангийн ирц, чанар сайжирч байгаа гэж үзэх үндэслэлтэй.

Газар дээрх болон зайны хяналтыг сайжруулж, шалгалтаар илэрсэн зөрчил дутагдлыг арилгуулахаар өгсөн үүрэг даалгаврын биелэлтийг тооцож танилцуулах ажлыг чанаржуулснаар тайлан мэдээ гаргах, нягтлан бодох бүртгэл хөтлөлттэй холбоотой алдаа, зөрчил дутагдал гарах нь багассан сайн талтай байгаагаас гадна ХЗХ-д тайлангийн хариу албан бичигтэй тухай бүр танилцаж, цаашид авах арга хэмжээгээ төлөвлөдөг, хянан шалгагчдаас ойлгомжгүй зүйлийг буцаан тодруулдаг зэрэг эргэх холбоо үүссэн сайн талтай байна.

Зохистой харьцааны шалгуур үзүүлэлтийг бүрэн хангаж буй ХЗХ-дын тоо өмнөх оны мөн үетэй харьцуулахад өссөн бөгөөд 2013 оны жилийн эцсийн байдлаар 16 ХЗХ зохистой харьцааны шалгуур үзүүлэлтүүдийг бүрэн хангаж ажилласан байна.

Статистик мэдээллээс үзэхэд ХЗХ-дын хугацаагүй хадгаламжийн дундаж хүү 0.9 хувь, хугацаатай хадгаламжийн хүү хугацаанаас хамааран дундаж хүү 1.66 хувь, зээлийн дундаж хүү 3.43 хувьтай байна.

2013 оны жилийн эцсийн байдлаар 141 ХЗХ үйл ажиллагаа эрхэлж байгаа нь 2012 оны мөн үетэй харьцуулахад тооны хувьд 7-оор буурсан хэдий ч санхүүгийн болон үйл ажиллагааны үндсэн үзүүлэлтүүдийн хувьд тодорхой хэмжээний өсөлтүүд гарч чанарын ахицтай байна.

Тухайлбал:

1. Нийт актив

Нийт активын хэмжээ өмнөх оны мөн үетэй харьцуулахад 6,120,884.2 мянган төгрөгөөр буюу 9.0 хувиар өсөж, банкны салбарын 0, 4 хувийг эзэлж байна. Улаанбаатар хотод үйл ажиллагаа эрхэлж буй ХЗХ-дын хувьд дундаж активын хэмжээ 1,110,914.0 мянган төгрөг, орон нутагт үйл ажиллагаа эрхэлж ХЗХ-ны дундаж активын хэмжээ 125,168.6 мянган төгрөг байна. Энэ нь өмнөх оны мөн үетэй харьцуулахад Улаанбаатар хотод үйл ажиллагаа эрхэлж буй ХЗХ-ны хувьд 199,218.8 мянган төгрөгөөр, орон нутгийн ХЗХ-ны хувьд 13,658.1 мянган төгрөгөөр тус тус өссөн үзүүлэлттэй байна.

2. Нийт зээлийн өрийн үлдэгдэл

Өмнөх оны мөн үетэй харьцуулахад зээлийн багц 1,050,358.4 мянган төгрөгөөр буюу 2.2 хувиар өсөж, банкны салбарын 0.5 хувийг эзэлж байна. Чанаргүй зээлийн өрийн хэмжээ өмнөх оны мөн үеэс 484,076.7 мянган төгрөг буюу 45.6 хувиар өссөн байна. Тайлант улиралд муу зээлийн хэмжээ өмнөх оны мөн үетэй харьцуулахад 31,700.8 мянган төгрөгөөр буурсан хэдий ч

зээлийн эрсдэлийн сангийн хэмжээ 196,853.7 мянган төгрөгөөр өсөж зээлийн чанар муудсан байна.

3. Татан төвлөрүүлсэн хадгаламж

ХЗХ-дын хадгаламжийн хэмжээ өмнөх оны мөн үеэс 3,596,019.5 мянган төгрөгөөр буюу 7.6 хувиар өсөж, банкны салбарын 0.8 хувийг эзэлж байна. Нийт мөнгөн хадгаламжийн 95.5 хувь нь хугацаатай, 4.5 хувь нь хугацаагүй хадгаламж байна.

4. Хувь хөрөнгийн хэмжээ

Хувь хөрөнгийн хэмжээ өмнөх оны мөн үетэй харьцуулахад 345,113.7 мянган төгрөгөөр өссөн байна.

5. Хоршоологчдын өмч

Хоршоологчдын өмчийн хэмжээ өмнөх оны мөн үеийн байдлаас 2,287,717.5 мянган төгрөгөөр өссөн. Хувь хөрөнгө болон хоршоологчдын өмчийн хэмжээ өссөн нь бусдын өмнө ХЗХ-дын хүлээх үүрэг хариуцлага өндөржиж, өөрийн хөрөнгийн чадавхи дээшилсэн эерэг үзүүлэлт гэж дүгнэж байна.

6. Нийт орлого, ашиг

ХЗХ-дын санхүүгийн үйл ажиллагаа сайжирч нийт орлогын хэмжээ өмнөх оны мөн үеэс 1,013,660.5 мянган төгрөгөөр, нийт зардлын хэмжээ 784,763.7 мянган төгрөгөөр тус тус өсч 2013 оны жилийн эцсийн байдлаар тайлант үеийн ашиг 4,069,315.6 мянган төгрөг байна. Тайлант үеийн ашгийг өмнөх оны мөн үеийн байдалтай харьцуулахад 228,896.8 мянган төгрөгөөр өссөн үзүүлэлттэй байна.

ХЗХ-доос 2013 оны зохицуулалтын үйлчилгээний хөлс 13,944.4 мянган төгрөгийг төсөвт төвлөрүүлэхээс 2013 оны байдлаар 13,944.4 мянган төгрөг буюу 100.0 хувийг төсөвт төвлөрүүлсэн ба улсын тэмдэгтийн хураамж болон тухайн үед төвлөрүүлэх зохицуулалт үйлчилгээний хөлс төлөх нэр бүхий 6 ХЗХ-ноос 1,000.0 мянган төгрөгийг бүрэн төвлөрүүлж, нийт 14,944.4 мянган төгрөг төсөвт төвлөрүүлсэн байна.

Аудитын тухай хуулиар ХЗХ-д нь санхүүгийн жилийн эцсийн тайлангаа баталгаажуулах үүрэгтэй. 2012 оны жилийн эцсийн санхүүгийн тайланг 145 хоршоо аудитын байгууллагаар баталгаажуулан ирүүлэхээс 97.9 хувь буюу 142 ХЗХ аудитын дүгнэлт, аудитлагдсан тайлангаа ирүүлээд байна.

Мөн “Хадгаламж, зээлийн хоршооны тухай” хуульд заасан хугацаанд хийсэн Бүх гишүүдийн ээлжит хурлын тэмдэглэл, шийдвэрийг 145 хоршоо ирүүлэх ёстойгоос 2013 оны жилийн эцсийн байдлаар 141 ХЗХ-ноос холбогдох баримт бичгийг Хороонд ирүүлсэн бөгөөд хуулийн хэрэгжилт 97.2 хувьтай байна.

2013 оны жилийн эцсийн байдлаар Зээлийн мэдээллийн тухай хуулийн дагуу Монголбанкны зээлийн мэдээллийн сантай мэдээлэл солилцох үүргээ хэрэгжүүлэн хамтран ажиллах гэрээ байгуулсан 40 ХЗХ байна. Орон нутагт үйл ажиллагаа ХЗХ -д байнгын интернет байхгүй, Монголбанкнаас тавьж буй техникийн шаардлагыг хангах боломжгүй байгаагаас хуулийн хэрэгжилт муу байна.

Мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх тухай хуулийн хэрэгжилтэнд хяналт тавих ажилтан томилж, холбогдох баримт бичгээ Хороонд ирүүлсэн 118 ХЗХ буюу хуулийн хэрэгжилт 83.7 хувийн биелэлттэй байна.

Тус хэлтсийн хянан шалгагчид 2013 онд Хорооны даргын баталсан 9 удаагийн тушаалаар нэр бүхий 36 ХЗХ-ны үйл ажиллагаанд газар дээрх хяналт шалгалтыг хийж 15 ХЗХ-нд УБАШ-аар хугацаатай үүрэг даалгавар өгч биелэлтийг хангуулсан , 11 ХЗХ-ны удирдлагуудад өрчлийн тэмдэглэл үйлдэн захиргааны арга хэмжээ авч 8,112.0 мянган төгрөгийн торгууль оногдуулж 7,414.8 мянган төгрөгийн торгуулийн мөнгийг төсөвт төвлөрүүлсэн бөгөөд хуулийн хэрэгжилт 91.4 хувьтай байна.

Цаашид "Хадгаламж, зээлийн хоршооны тухай" хууль, Мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх тухай хууль, Зээлийн мэдээллийн тухай хуулиудын хэрэгжилтийг хангуулахад анхаарч ажиллах, орон нутгийн хоршоодод газар дээрх үзлэг, шалгалтыг хийж бодит нөхцөл байдалд дүгнэлт өгөхөөр төлөвлөн ажиллаж байна.

## ХАДГАЛАМЖ, ЗЭЭЛИЙН ХОРШООДЫН ХЭЛТЭС